

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/89/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatart@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582. Цахим шуудан: tiv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

᠔᠒᠔᠔.᠒᠔.᠒5 № ᠒/᠑7
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
М.ОТГОНБАТ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймаг нь гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд аймгийн хэмжээнд нийт 3,000.0 сая төгрөгийн бодит хөрөнгө оруулалт, 90.0 сая төгрөгийн оюуны хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Төв аймгийн түүхт 100 жилийн ойн хүрээнд тохижилт, хөрөнгө оруулалтын ажлууд, түүхэн боть ном, контентууд хийгдсэн байна.
- Дайчилгаатай холбоотой сургалт дадлагуудыг зохион байгуулж, материаллаг баазыг бүрдүүлсэн байна.
- Өвөлжилт хүндэрсэн сумдад яаралтай арга хэмжээг авч зудын эрсдэлд хариу арга хэмжээ авч ажилласан байна.
- Монгол өв соёлын өргөөний бүтээн байгуулалт болон конторын барилгын их засварын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	337,510,640.00	800,381,631.00
33	АВЛАГА	129,039,113.00	13,684,396.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	126,981,450.00	3,311,821.00
33500	Бусад авлага	2,057,663.00	10,372,575.00
33510	Байгууллагаас авах авлага	2,057,663.00	10,372,575.00
35	БАРАА МАТЕРИАЛ	208,471,527.00	786,697,235.00
35100	Түүхий эд материал	19,429,952.00	19,429,952.00
35110	Тусгай зориулалттай материал	19,429,952.00	19,429,952.00
35400	Хангамжийн материал	189,041,575.00	767,267,283.00
35410	Бичиг хэргийн материал	1,200,300.00	2,261,000.00
35420	Аж ахуйн материал	185,183,713.00	760,413,864.00
35430	Сэлбэг хэрэгсэл	210,000.00	0
35440	Түлш, шатах тослох материал	2,447,562.00	4,592,419.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,304,165,986.90	6,504,999,292.02
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,304,165,986.90	6,504,999,292.02
39200	Биет хөрөнгө	3,048,232,765.88	6,233,627,737.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,907,716,446.00	6,188,319,453.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-303,892,298.53	-418,869,771.71
39203	Авто-тээврийн хэрэгсэл	556,000,000.00	590,346,067.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-432,683,333.42	-504,187,733.78
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	631,223,732.41	750,608,863.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	-373,140,018.65	-444,523,543.39
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	323,815,158.35	347,885,718.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	-260,906,011.49	-276,045,346.41
39214	Бусад үндсэн хөрөнгө	76,275,191.00	76,275,191.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-76,176,099.79	-76,181,159.83
39300	Биет бус хөрөнгө	255,933,221.02	271,371,554.38
39301	Програм хангамж	95,500,000.00	95,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-22,866,778.98	-38,553,445.62
39303	Бусад биет бус хөрөнгө	183,300,000.00	214,425,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,641,676,626.90	7,305,380,923.02
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	455,490.00	19,807,034.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	455,490.00	19,807,034.00
41300	Өглөг	455,490.00	19,807,034.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	455,490.00	16,349,344.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	1,352,869.00
41360	Бусад өглөг	0	2,104,821.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0	2,104,821.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,641,221,136.90	7,285,573,889.02
51	Засгийн газрын хувь оролцоо	3,641,221,136.90	7,285,573,889.02
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,633,996,434.32	1,633,996,434.32
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,633,996,434.32	1,633,996,434.32
51200	Хуримтлагдсан үр дүн	882,584,432.88	4,526,937,185.00
51210	Өмнөх үеийн үр дүн	668,884,272.79	882,584,432.88
51220	Тайлант үеийн үр дүн	213,700,160.09	3,644,352,752.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,124,640,269.70	1,124,640,269.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,641,676,626.90	7,305,380,923.02

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,764,632,548.17	10,614,601,510.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	92,843,500.00	3,808,288,912.00
120	Нийтлэг татварын бус орлого	92,843,500.00	3,808,288,912.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	17,353,794.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	17,353,794.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	92,843,500.00	3,790,935,118.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,671,789,048.17	6,806,312,598.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,648,646,748.17	1,194,880,898.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	208,343,646.00	544,757,381.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,440,303,102.17	650,123,517.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,023,142,300.00	5,611,431,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,023,142,300.00	5,611,431,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,550,932,388.08	6,970,248,757.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,550,932,388.08	6,889,640,867.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,911,869,220.08	6,660,786,814.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,222,200,667.50	2,167,798,114.48
210101	Үндсэн цалин	827,428,410.80	1,218,198,617.48
210102	Нэмэгдэл	71,182.00	652,731,060.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	99,267,000.00
210104	Урамшуулал	0	146,735,379.00
210105	Гэрээт ажлын хөлс	394,701,074.70	50,866,058.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147,845,082.50	258,672,589.52
210201	Тэтгэврийн даатгал	101,491,669.50	175,862,208.52
210202	Тэтгэмжийн даатгал	11,461,236.00	20,384,580.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,168,989.00	16,307,663.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,199,602.00	3,958,668.00
210205	Эрүүл мэндийн даатгал	23,523,586.00	42,159,470.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	303,014,549.00	367,063,857.88
210301	Гэрэл, цахилгаан	28,174,254.00	46,885,476.48
210302	Түлш, халаалт	263,382,988.00	310,298,445.40
210303	Цэвэр, бохир ус	11,457,307.00	9,879,936.00
2104	Хангамж, бараа материалын зардал	80,276,524.00	75,945,520.86
210401	Бичиг хэрэг	15,732,640.00	15,564,280.00
210402	Тээвэр, шатахуун	41,622,519.00	46,657,843.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,981,865.00	13,723,397.86
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,939,500.00	0
2105	Нормативт зардал	0	6,690,959.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0	6,690,959.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	455,436,372.00	22,635,480.00
210604	Урсгал засвар	455,436,372.00	22,635,480.00
2107	Томилолт, зочны зардал	19,830,000.00	36,143,800.00
210702	Дотоод албан томилолт	19,830,000.00	36,143,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	138,617,932.00	58,829,364.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	129,998,747.00	52,809,198.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	2,336,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,083,000.00	1,958,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	426,098.00	591,166.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	264,000.00	187,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,996,087.00	948,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,544,648,093.08	3,667,007,128.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,285,281,066.80	3,420,121,453.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	64,178,900.00	17,398,798.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	195,188,126.28	229,486,877.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	639,063,168.00	228,854,053.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,529,221.00	46,132,225.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	16,156,420.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,762,819.00	25,813,205.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,766,402.00	4,162,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	581,533,947.00	182,721,828.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	86,109,376.00	80,975,537.26
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	495,424,571.00	101,746,291.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	80,607,890.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	80,607,890.00
221001	Их засвар	0	80,607,890.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	213,700,160.09	3,644,352,752.12
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	213,700,160.09	3,644,352,752.12

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,667,767,732.80	6,876,435,630.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,850,200.00	17,353,794.00
120	Нийтлэг татварын бус орлого	15,850,200.00	17,353,794.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,850,200.00	17,353,794.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,850,200.00	17,353,794.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,651,917,532.80	6,859,081,836.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,628,775,232.80	1,247,650,136.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0	350,769,180.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	208,343,646.00	293,988,201.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,420,431,586.80	602,892,755.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,023,142,300.00	5,611,431,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,023,142,300.00	5,611,431,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,472,867,732.80	6,776,455,630.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,472,867,732.80	6,776,455,630.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,833,804,564.80	6,547,401,576.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,065,952,988.99	2,169,070,708.00
210101	Үндсэн цалин	616,385,548.99	1,219,471,159.31
210102	Нэмэгдэл	220,301,265.00	652,731,060.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	67,367,670.00	99,267,050.80
210104	Урамшуулал	62,947,455.00	146,735,379.00
210105	Гэрээт ажлын хөлс	98,951,050.00	50,866,058.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,916,916.01	243,325,542.00
210201	Тэтгэврийн даатгал	94,336,825.50	160,481,595.86
210202	Тэтгэмжийн даатгал	10,644,772.47	20,735,295.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,275,577.98	18,096,281.14
210204	Ажилгүйдлийн даатгал	2,369,194.50	4,156,674.02
210205	Эрүүл мэндийн даатгал	21,290,545.56	39,855,695.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	302,900,295.00	365,570,988.88
210301	Гэрэл, цахилгаан	28,060,000.00	45,332,607.48
210302	Түлш, халаалт	263,382,988.00	309,430,859.40
210303	Цэвэр, бохир ус	11,457,307.00	10,807,522.00
2104	Хангамж, бараа материалын зардал	76,985,335.00	78,999,377.86
210401	Бичиг хэрэг	9,878,100.00	15,502,970.00
210402	Тээвэр, шатахуун	44,283,100.00	48,424,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,884,635.00	15,072,407.86
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,939,500.00	0
2105	Нормативт зардал	7,917,688.00	11,068,339.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,917,688.00	11,068,339.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	475,802,262.00	62,474,000.00
210604	Урсгал засвар	475,802,262.00	62,474,000.00
2107	Томиллолт, зочны зардал	19,830,000.00	36,143,800.00
210702	Дотоод албан томиллолт	19,830,000.00	36,143,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	286,929,742.00	30,564,421.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	257,697,227.00	18,000,000.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	2,336,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,083,000.00	1,958,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	426,098.00	591,166.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	264,000.00	187,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,609,417.00	7,492,255.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,460,569,337.80	3,550,184,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,394,336,437.80	3,518,335,848.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	66,232,900.00	31,848,552.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	639,063,168.00	229,054,053.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,529,221.00	46,332,225.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	16,156,420.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,762,819.00	25,813,205.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,766,402.00	4,362,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	581,533,947.00	182,721,828.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	86,109,376.00	80,975,537.26
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	495,424,571.00	101,746,291.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	194,900,000.00	99,980,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	194,900,000.00	99,980,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	194,900,000.00	99,980,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	194,900,000.00	99,980,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	194,900,000.00	99,980,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-194,900,000.00	-99,980,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,633,996,434.32	1,130,627,502.70	662,897,039.79	3,427,520,976.81
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,633,996,434.32	1,124,640,269.70	882,584,432.88	3,641,221,136.90
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,633,996,434.32	1,124,640,269.70	668,884,272.79	3,427,520,976.81
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	-5,987,233.00	5,987,233.00	0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	213,700,160.09	213,700,160.09
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,633,996,434.32	1,124,640,269.70	882,584,432.88	3,641,221,136.90
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,633,996,434.32	1,124,640,269.70	4,526,937,185.00	7,285,573,889.02
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,633,996,434.32	1,124,640,269.70	882,584,432.88	3,641,221,136.90
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0

15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	3,644,352,752.12	3,644,352,752.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,711,431,700.00	5,547,809,956.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,661,431,700.00	5,497,809,956.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,609,565,300.00	5,451,477,731.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,934,473,300.00	1,932,267,549.00
210101	Үндсэн цалин	1,249,764,700.00	1,134,476,020.31
210102	Нэмэгдэл	414,357,000.00	551,748,420.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,604,000.00	91,556,887.80
210104	Урамшуулал	0	103,620,162.00
210105	Гэрээт ажлын хөлс	220,747,600.00	50,866,058.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	241,809,300.00	223,557,113.00
210201	Тэтгэврийн даатгал	164,430,200.00	146,178,013.00
210202	Тэтгэмжийн даатгал	19,344,800.00	19,344,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,475,800.00	15,475,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,869,000.00	3,869,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	38,689,500.00	38,689,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	394,066,400.00	365,570,988.88
210301	Гэрэл, цахилгаан	46,363,000.00	45,332,607.48
210302	Түлш, халаалт	335,441,300.00	309,430,859.40
210303	Цэвэр, бохир ус	12,262,100.00	10,807,522.00
2104	Хангамж, бараа материалын зардал	82,924,700.00	78,999,377.86
210401	Бичиг хэрэг	17,000,000.00	15,502,970.00
210402	Тээвэр, шатахуун	48,424,700.00	48,424,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,500,000.00	15,072,407.86
2105	Нормативт зардал	14,475,000.00	11,068,339.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,475,000.00	11,068,339.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,000,000.00	25,000,000.00
210604	Урсгал засвар	25,000,000.00	25,000,000.00
2107	Томиллолт, зочны зардал	37,853,900.00	36,143,800.00
210702	Дотоод албан томиллолт	37,853,900.00	36,143,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,842,700.00	30,564,421.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,000,000.00	18,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,336,000.00	2,336,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,958,000.00	1,958,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,000,000.00	591,166.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	500,000.00	187,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,048,700.00	7,492,255.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,845,120,000.00	2,748,306,143.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,838,020,000.00	2,742,146,543.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,100,000.00	6,159,600.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,866,400.00	46,332,225.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,866,400.00	46,332,225.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,438,100.00	16,156,420.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,032,300.00	25,813,205.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,396,000.00	4,362,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,000,000.00	50,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	50,000,000.00	50,000,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,711,431,700.00	5,547,809,956.74
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,699,431,700.00	5,530,456,162.74
320001	Орон нутгийн төсвөөс	5,699,431,700.00	5,530,456,162.74
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	12,000,000.00	17,353,794.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,000,000.00	17,353,794.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	149	149
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	74	74
620001	Удирдах ажилтан	10	10
620002	Гүйцэтгэх ажилтан	33	33
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	28	28
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	74	74
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	36	36
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	4	4
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	31	31
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	3	3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,628,775,232.80	1,247,650,136.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,493,875,232.80	1,197,670,136.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	998,450,661.80	1,095,923,845.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,560,827.99	236,803,159.00
210101	Үндсэн цалин	11,543,342.99	84,995,139.00
210102	Нэмэгдэл	1,728,313.00	100,982,640.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,833,000.00	7,710,163.00
210104	Урамшуулал	456,172.00	43,115,217.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,929,068.01	19,768,429.00
210201	Тэтгэврийн даатгал	1,771,177.50	14,303,582.86
210202	Тэтгэмжийн даатгал	39,472.47	1,390,495.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	31,577.98	2,620,481.14
210204	Ажилгүйдлийн даатгал	7,894.50	287,674.02
210205	Эрүүл мэндийн даатгал	78,945.56	1,166,195.82
2104	Хангамж, бараа материалын зардал	10,939,500.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,939,500.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	429,312,162.00	37,474,000.00
210604	Урсгал засвар	429,312,162.00	37,474,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,999,010.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,999,010.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	530,710,093.80	801,878,257.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	467,810,493.80	776,189,305.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	62,899,600.00	25,688,952.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	495,424,571.00	101,746,291.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	495,424,571.00	101,746,291.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	495,424,571.00	101,746,291.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	134,900,000.00	49,980,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	134,900,000.00	49,980,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	134,900,000.00	49,980,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,628,775,232.80	1,247,650,136.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,628,775,232.80	1,247,650,136.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	350,769,180.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	208,343,646.00	293,988,201.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,420,431,586.80	602,892,755.00

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Засаг даргын Тамгын газар нь төрийн үйлчилгээний бүтээмжийг нэмэгдүүлэх замаар аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн тогтвортой өсөлтийг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн захиргааны байгууллага юм.

Төв аймгийн Засаг даргын тамгын газар нь тайлант онд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг эдийн засагжуулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- Эдийн засгийн бүтэц дэх боловсруулах үйлдвэр, үйлчилгээний салбарыг дэвшилтэт технологи, инновацад суурилан хөгжүүлж, ДНБ-ий жилийн дундаж өсөлтийг 10 хувьд хүргэнэ.
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний гүйцэтгэл, үр дүнг сайжруулж, ISO стандартын баталгаажуулалт хийлгэнэ.
- Хууль сахиулах байгууллагын салбарын хөгжлийг дэмжиж ажиллана.
- Төсөв, санхүүгийн хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллана.
- Нийгмийн салбарын төсөл, арга хэмжээг дэмжин ажиллана.
- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ.
- Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- Аймгийн Засаг даргын ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Төв аймгийн Засаг даргын тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, хэрэгжүүлэх 69 арга хэмжээтэй баталснаас нийт 93,2 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Засаг даргын тамгын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шаардлагагүй гэж үзсэн.

Төв аймгийн Засаг даргын тамгын газарт дотоод аудитын нэгж байхгүй ба Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Аудитын явцад дотоод хяналтын багийн жилийн ажлын төлөвлөгөө, баримт материалыг ирүүлээгүй болно.

Төв аймгийн Засаг даргын тамгын газарт аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албаас 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 90,801.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,320.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосон байна.

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос хоёр дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	129,039.1	13,684.4	-115,354.7
Бараа материал	208,471.5	786,697.2	578,225.7
Үндсэн хөрөнгө	3,304,165.9	6,504,999.3	3,200,833.4
Нийт хөрөнгө	3,641,676.6	7,305,380.9	3,663,704.3
Өр төлбөр	455.4	19,807.0	19,351.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,641,221.1	7,285,573.9	3,644,352.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,641,676.6	7,305,380.9	3,663,704.3

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд авлага данс эцсийн үлдэгдэл 13,684.4 мянган төгрөг болж буурсан нь 100 жилийн ойн тоглолтын билетийн үнэ, баримтат кино, ном, телевизийн

нэвтрүүлгийн урьдчилгаа төлбөрийн авлагууд барагдсанаас шалтгаалсан байна. Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 786,697.2 мянган төгрөг болж 578,225.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн 100 жилийн ойн арга хэмжээтэй, дайчилгаатай холбоотой худалдан авалттай холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 6,504,999.3 мянган төгрөг болж, 3,663,352.8 мянган төгрөгөөр өссөн нь татан буугдсан мэргэжлийн хяналтын газрын хөрөнгүүд шилжин ирсэн, үндсэн хөрөнгийн худалдан авалтууд хийгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 19,807.0 мянган төгрөг болж 19,351.6 мянган төгрөгөөр өссөн нь харилцагч байгууллагуудтай тооцоо нийлээгүйгээс өр үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны эцсийн үлдэгдэл 7,285,573.9 мянган төгрөг болж 3,644,352.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 3,175,375.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлсэн байна.

Төв аймгийн Засаг даргын тамгын газраас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлсэн төсвийн төслийн дүнг 140,232.8 мянган төгрөгөөр бууруулж 2023 оны урсгал зардлын төсвийг 3,035,142.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 3,035,142.3 мянган төгрөгт 1 удаа тодотгол хийж 5,711,431.7 мянган төгрөгөөр баталж төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,547,809.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 5,547,809.9 мянган төгрөгийг зарцуулж, 80,975.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,547,809.9 мянган төгрөг буюу 97,1 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106/80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	2,003,869.3	1,956,103.9	47,765.3	97.6%
2	70106/80102 Туслах үйл ажиллагааны зардал	327,936.8	313,725.6	14,211.2	95.6%
3	70106/80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	463,259.2	462,521.6	737.6	99.8%
4	70106/80219 Харуул, хамгаалалтын зардал	14,500.0	14,500.0	0.0	100.0%
5	70106/80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал, урамшуулал	51,866.4	46,332.2	5,534.2	89.3%
6	70106/80918 Бусад	50,000.0	50,000.0	0.0	100.0%
7	70106/81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	2,150,000.0	2,057,794.7	92,205.3	95.7%
8	70106/81518 Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зардал	600,000.0	600,000.0	0.0	100.0%
9	70106/82801 Улсын их баяр наадам	50,000.0	46,831.8	3,168.2	93.6%

	ДҮН	5,711,431.7	5,547,809.9	163,621.8	97.1%
--	-----	-------------	-------------	-----------	-------

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд 100 жилийн ойн тоглолтын билетийн мөнгө, хандив, бусад орлого 605,130.4 мянган төгрөг, Засаг даргын захирамжаар 642,519.7 мянган төгрөг, нийт 1,247,650.1 мянган төгрөгийн орлого орсноос цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 256,571.6 мянган төгрөг, урсгал засварын зардалд 37,474.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 776,189.3 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 25,688.9 мянган төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 49,980.0 мянган төгрөг, нийт 1,247,650.1 мянган төгрөгийг зарцуулж, 101,746.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	/мянган төгрөгөөр/		
				Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Хөтөлбөр 93.2 %	5,711,431.7	5,547,809.9

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Засаг даргын тамгын газар нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр урсгалд 506,786.1 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 1,201,700.0 мянган төгрөгийн 10 худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна. Харин 10 аж ахуйн нэгжтэй холбоотой 525,991.7 мянган төгрөгийн худалдан авалтыг худалдан авах ажиллагаа зарлалгүй хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны 02/154 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Засаг даргын тамгын газрын батлагдсан 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 4,764,339.8 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 71,465.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 53,598.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Засаг даргын тамгын газарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад мэдээлбэл зохих 171 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроосон, мэдээлээгүй мэдээлэл байхгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж, 4 албан шаардлага өгснийг 99,2% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 02/1182 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	4	720,344.6	3	709,382.5	98.4%
Зөвлөмж	2	136,926.4	2	136,926.4	100.0%
Нийт дүн	6	857,271.0	5	846,308.9	99.2%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар гадаад албан томилолтын зардлыг авч үзнэ. Мөн Аймгийн 100 жилтэй холбоотой хандив тусламж нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан худалдан авалтыг ОНХС-ын гүйцэтгэлийн аудитаар авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

Аудитаар нийт 8,551.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залрууллаа. Үүнд:

Үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу бодогдсон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Өмнөх оны аудитаар засаг даргын орлогчийг зөвлөхөөр томилон ажиллуулсан зөрчилд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй 25,817.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-д “Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно”, 5.4-д “Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно” гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтын дагуу төлбөрийн акт тогтоов.

2. Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн “Төрийн албан хаагчдын ангилал зэрэглэл, цалин хөлсийг шинэчлэн тогтоож, орон нутгийн нэмэгдэл олгох тухай” Б/02 тоот захирамжаар төрийн улс төрийн 2 албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл цалинд 5,045.1 мянган төгрөг олгосон зөрчил илэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 тоот тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

5.2 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд харилцагч байгууллагуудтай тооцоо нийлэлгүй ХХОАТ, НДШ болон гэрэл цахилгааны 19,807.0 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7-д “авлага өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

2. Нийт 10 аж ахуйн нэгжтэй холбоотой 525,991.7 мянган төгрөгийн худалдан авалтыг худалдан авах ажиллагаа зарлалгүй хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”, 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.9-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

3. Төсвөөс ганданд ном уншуулахад 1,000.0 мянган төгрөг, шинэ жилийн арга хэмжээнд 25,749.3 мянган төгрөг, Ургац хураалтын амжилтыг дүгнэх бөхийн барилдаанд 12,026.0 мянган төгрөг, Алтан гурвалжин ёслолын арга хэмжээнд 10,000.0 мянган төгрөг, хууль эрхзүйн зөвлөгөө авахад 15,000.0 мянган төгрөг нийт 63,775.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

4. Улсын онцгой комиссоос Урал 375 маркын автомашин өгснийг орлогод аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

5. Гадаад албан томилолтын зардлын төсөв батлагдаагүй байхад засаг даргын нөөцөөс 30,833.0 мянган төгрөг, мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас 43,968.4 мянган төгрөг, нийт 74,801.4 мянган төгрөгийн гадаад албан томилолт болон тийзийн зардал гаргасан байна. Энэ нь

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.1-д “Нөөц хөрөнгийг зарцуулах тухай Засаг даргын шийдвэрийн төсөл нь дор дурдсан шаардлагыг хангасан байна”, 3.1.2-д “урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх” гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

6. Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд аж ахуйн нэгж байгууллагаас хандив авч 100 жилийн ойд болон баримал хийхэд зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-д “Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно”, 25.2.1-д “эмнэлгийн үйлчилгээ”, 25.2.2-д “бүх шатны боловсролын үйлчилгээ”, 25.2.3-д “соёлын үйлчилгээ”, 25.2.4-д “хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх” гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Монгол өв соёлын өргөө цогцолборыг түрээслүүлсэн ажиллуулсан боловч түрээсийн орлогыг төвлөрүүлээгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5-д “бүх орлого” гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид гэрээний нөхцөлийг хангуулж түрээсийн төлбөрийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлага тусгаагүй	1	8,551.1	1	8,551.1			1	8,551.1				
Дүн	1	8,551.1	1	8,551.1			1	8,551.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.	1	25,817.0	1	25,817.0								
Төрийн улс төрийн албан тушаалтнуудад орон нутгийн нэмэгдэл олгосон.	1	5,045.1	1	5,045.1								
Тендер зарлалгүй худалдан авалт хийсэн	1	525,991.7			1	525,991.7						
ХХОАТ, НДШ, Гэрэл цахилгааны өглөг үүсгэсэн байна.	1	19,807.0			1	19,807.0						
Улсын онцгой комиссоос Урал 375 маркын автомашин өгснийг орлогод	1	30,000.0			1	30,000.0						

аваагүй байна.												
Гадаад албан томилолтын зардал батлагдаагүй байхад зардал гаргасан:	1	74,801.4			1	74,801.4						
Төсвийн үр ашиггүй зарцуулсан	1	63,775.3			1	63,775.3						
Байгууллагын нэмэлт санхүүжилтий н дансанд аж ахуйн нэгж байгууллагаас хандив авч 100 жилийн ойд болон баримал хийхэд зарцуулсан байна.	1	104,000.0			1	104,000.0						
Монгол өв соёлын өргөө цогцолборыг түрээслүүлсэн ажиллуулсан боловч түрээсийн орлогыг төвлөрүүлээгү й байна.	1	9,967.8					1	9,967.8				
Дүн	9	859,205.4	2	30,862.1	6	818,375.4	1	9,967.8				